САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

FINANCIAL REGULATORY COMMISSION OF MONGOLIA

# ДААТГАЛЫН САЛБАРЫН 2017 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ

# Агуулга

**1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ......2**
1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ......2
1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ......3
1.3.ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ......4
1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ......5
1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР......8
1.6.ДААТГАЛЫН НӨӨЦ САН......9
1.7.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА......9
1.8.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА......10
**2.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ......10**
**3.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ......11**
3.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ......11
3.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ......13

# 1.ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

## 1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2017 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 40, даатгалын хохирол үнэлэгч 31 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 239 салбар, 11 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 209 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 50 салбар, 3 төлөөлөгчийн газар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт-1

**Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо**

| № | | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017.III |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ердийн даатгалын компани | 16 | 16 | 15 | 15 | 15 |
| 2 | Урт хугацааны даатгалын компани | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 3 | Давхар даатгалын компани | | | 1 | 1 | 1 |
| 4 | Даатгалын төлөөлөгч | 3187 | 3260 | 3340 | 3091 | 2893 |
| 5 | Даатгалын зуучлагч | 20 | 30 | 37 | 40 | 40 |
| 6 | Даатгалын хохирол үнэлэгч | 14 | 20 | 27 | 31 | 31 |
| 7 | Актуарч | 15 | 15 | 15 | 15 | 21 |
| 8 | Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани | | | | 42 | 42 |
| 9 | Аудитор | | | | 126 | 126 |
| | **БҮГД** | **3253** | **3342** | **3436** | **3362** | **3170** |

Хүснэгт-2

**Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо**

| № | | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017.III |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар | 251 | 254 | 258 | 252 | 250 |
| 2 | Даатгалын зуучлагч компанийн салбар | 64 | 135 | 171 | 208 | 209 |
| 3 | Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар, төлөөлөгчийн газар | 8 | 42 | 52 | 52 | 53 |
| | **БҮГД** | **323** | **431** | **481** | **513** | **512** |

***2017 оны 3 дугаар улиралд:*** Хорооны 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 190 дүгээр тогтоолоор "Чанд финтех" ХХК-д, 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон. Хорооны 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 166 дугаар тогтоолоор "Капитал эстимэйт" ХХК-ийн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

## 1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Тайлант хугацаанд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 251.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44.3 тэрбум төгрөгөөр буюу 22.3 хувиар өссөн байна.

Дүрслэл-1




Даатгалын компаниудын нийт хөрөнгийн салбарын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 80.0 хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 17.0 хувь, урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 3.0 хувийг тус тус эзэлж байна. Ердийн, урт хугацааны болон давхар даатгалын компаниудын хөрөнгө, салбарын нийт хөрөнгөд эзлэх хувийг дараах дүрслэл болон хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

Дүрслэл-2



Хүснэгт-3

**Даатгалын компаниудын нийт хөрөнгө**

| Компани | Нийт хөрөнгийн дүн | | Өсөлт/ бууралт |
|---|---|---|---|
| | 2016.09.30 | 2017.09.30 | |
| Ард даатгал | 9,566,344,802.82 | 11,584,894,181.94 | 21.1% |
| Бодь даатгал | 12,078,944,229.21 | 21,298,386,345.31 | 76.3% |
| Ган зам даатгал | 6,560,166,458.91 | 7,148,649,282.44 | 9.0% |
| Гэр даатгал | 5,347,026,140.81 | 6,206,134,985.59 | 16.1% |
| Мандал женерал даатгал | 14,020,628,761.25 | 21,999,856,896.26 | 56.9% |
| Миг даатгал | 11,752,850,184.07 | 15,652,541,981.80 | 33.2% |
| Монгол даатгал | 36,970,480,585.33 | 36,445,824,072.54 | -1.4% |
| Монре даатгал | 6,347,498,641.40 | 7,095,960,633.55 | 11.8% |
| Мөнх даатгал | 4,300,015,481.00 | 4,659,712,332.00 | 8.4% |
| Номин даатгал | 10,203,392,950.77 | 11,241,590,425.09 | 10.2% |
| Практикал даатгал | 11,071,663,623.42 | 13,144,295,283.93 | 18.7% |
| Соёмбо даатгал | 9,569,267,485.51 | 10,302,306,520.58 | 7.7% |
| Тэнгэр даатгал | 15,783,241,623.23 | 19,574,408,195.68 | 24.0% |
| Улаанбаатар хотын даатгал | 5,579,423,084.46 | 5,815,695,113.85 | 4.2% |
| Хаан даатгал | 7,816,353,581.97 | 9,089,662,343.85 | 16.3% |
| Нэйшнл лайф даатгал | 7,479,199,624.66 | 7,587,953,083.90 | 1.5% |
| ХАА-н давхар даатгал | 32,965,539,436.60 | 42,872,274,282.53 | 30.1% |
| **Нийт дүн** | **207,412,036,695.42** | **251,720,145,960.84** | **20.2%** |

## 1.3.ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 13.4 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 24.0 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 7.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Сүүлийн 5 жилд даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн өсөх хандлагатай байгааг дараах дүрслэлээр харуулав.

Дүрслэл-3

**Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч /тэрбум төгрөг/**



Эзэмшигчдийн өмчийн өсөлтийн шалтгаан нь Хорооны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн батлах” тухай 355 дугаар тогтоолын дагуу зарим нэр бүхий компаниудын дүрмийн сангийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт-4

**Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч, нөөц сан /төгрөгөөр/**

| Даатгалын компани | Нөөц сангийн дүн | Өр төлбөрийн дүн | Эздийн өмч | Өр төлбөр ба эздийн өмчийн дүн |
|---|---|---|---|---|
| Ард даатгал | 1,373,580,483.8 | 5,786,695,182.2 | 4,424,618,516.0 | 11,584,894,181.9 |
| Бодь даатгал | 2,838,932,643.2 | 12,722,866,054.8 | 5,736,587,647.3 | 21,298,386,345.3 |
| Ган зам даатгал | 742,043,591.0 | 368,923,861.8 | 6,037,681,829.7 | 7,148,649,282.4 |
| Гэр даатгал | 858,993,532.5 | 505,964,772.0 | 4,841,176,681.2 | 6,206,134,985.6 |
| Мандал женерал даатгал | 2,766,857,508.6 | 13,726,816,852.7 | 5,506,182,535.0 | 21,999,856,896.3 |
| Миг даатгал | 3,041,802,774.7 | 6,599,077,515.0 | 6,011,661,692.1 | 15,652,541,981.8 |
| Монгол даатгал | 11,245,690,238.1 | 15,177,654,715.6 | 10,022,479,118.9 | 36,445,824,072.5 |
| Монре даатгал | 614,835,927.6 | 1,992,676,286.1 | 4,488,448,419.9 | 7,095,960,633.6 |
| Мөнх даатгал | 303,396,866.0 | 184,288,379.0 | 4,172,027,087.0 | 4,659,712,332.0 |
| Номин даатгал | 4,370,162,267.4 | 2,250,859,025.8 | 4,620,569,132.0 | 11,241,590,425.1 |
| Практикал даатгал | 3,425,456,291.4 | 4,134,967,020.7 | 5,583,871,971.8 | 13,144,295,283.9 |
| Соёмбо даатгал | 2,454,384,188.4 | 2,443,756,298.5 | 5,404,166,033.7 | 10,302,306,520.6 |
| Тэнгэр даатгал | 4,322,487,118.3 | 7,618,263,019.4 | 7,633,658,058.0 | 19,574,408,195.7 |
| Улаанбаатар хотын даатгал | 1,046,058,360.0 | 374,385,000.0 | 4,395,251,753.9 | 5,815,695,113.9 |
| Хаан даатгал | 1,839,082,820.5 | 2,003,549,427.5 | 5,247,030,095.9 | 9,089,662,343.9 |
| Нэйшнл лайф даатгал | 1,403,616,217.4 | 3,309,196.9 | 6,181,027,669.7 | 7,587,953,083.9 |
| Хөдөө аж ахуйн давхар даатгал | 20,252,864,472.9 | 758,455,330.6 | 21,860,954,479.1 | 42,872,274,282.5 |
| **Нийт** | **62,900,245,301.4** | **76,652,507,938.4** | **112,167,392,721.1** | **251,720,145,960.8** |

## 1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ

Даатгалын компаниуд 2017 оны 3 дугаар улиралд 840,718 иргэн, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 114.6 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсний 98.7 хувь буюу 112.0 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.9 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани, 1.3 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг давхар даатгалын компани эзэлж байна. Тайлант улирлын даатгалын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 17.3 хувь өсөлттэй байна.

**Даатгалын нийт хураамжийн орлого, давхар даатгалын хураамж /тэр бум төгрөг/**




Хүснэгт-5

**Даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын хураамж /төгрөгөөр/**

| № | Даатгалын компани | Даатгалын хураамжийн нийт орлого | Даатгалын хураамжийн буцаалт | Давхар даатгалын хураамжийн зардал | Даатгалын хураамжийн цэвэр орлого |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ард даатгал | 7,670,307,585.2 | 100,402,241.4 | 2,646,128,171.1 | 4,923,777,172.6 |
| 2 | Бодь даатгал | 24,973,782,850.4 | 267,237,633.8 | 16,009,072,404.3 | 8,697,472,812.3 |
| 3 | Ган зам даатгал | 497,496,439.2 | 167,169.0 | .0 | 497,329,270.2 |
| 4 | Гэр даатгал | 730,550,212.0 | 54,076,857.4 | .0 | 676,473,354.6 |
| 5 | Мандал женерал даатгал | 17,162,735,410.1 | 631,137,745.9 | 10,535,544,983.8 | 5,996,052,680.4 |
| 6 | Миг даатгал | 10,724,647,954.5 | 316,882,069.4 | 458,854,393.7 | 9,948,911,491.4 |
| 7 | Монгол даатгал | 19,932,403,489.9 | 536,143,717.4 | 6,476,672,853.4 | 12,919,586,919.2 |
| 8 | Монре даатгал | 3,070,916,189.8 | 135,141,903.7 | 88,395,841.1 | 2,847,378,444.9 |
| 9 | Мөнх даатгал | 657,280,680.0 | .0 | .0 | 657,280,680.0 |
| 10 | Номин даатгал | 3,568,880,192.1 | 144,802,817.7 | 248,502,327.7 | 3,175,575,046.8 |
| 11 | Практикал даатгал | 6,374,372,253.9 | 149,607,883.2 | 507,089,019.5 | 5,717,675,351.2 |
| 12 | Соёмбо даатгал | 3,503,392,418.5 | 93,054,240.2 | 400,917,797.4 | 3,009,420,380.8 |
| 13 | Тэнгэр даатгал | 9,024,226,237.7 | 361,186,436.1 | 3,501,064,733.6 | 5,161,975,067.9 |
| 14 | Улаанбаатар хотын даатгал | 476,972,392.7 | 797,281.0 | .0 | 476,175,111.7 |
| 15 | Хаан даатгал | 3,667,037,555.3 | 70,987,395.2 | 110,632,449.2 | 3,485,417,710.9 |
| 16 | Нэйшнл лайф даатгал | 995,632,254.9 | 20,497.0 | 18,224,885.0 | 977,386,872.9 |
| 17 | Хөдөө аж ахуйн давхар даатгал | 1,541,439,662.9 | | 1,005,616,347.1 | 535,823,315.9 |
| | **Нийт** | **114,572,073,779.4** | **2,861,645,888.4** | **42,006,716,207.1** | **69,703,711,683.9** |

Тайлант хугацааны даатгалын хураамжийн нийт орлогын 71.4 хувь нь даатгалын 4 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдэж байгаагийн 26.7 хувийг хөрөнгийн даатгал, 21.5 хувийг ЖХАЖД, 12.0 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 11.2 хувийг гэнэтийн ослын даатгалын хураамж тус тус эзэлж байна.

Хүснэгт-6

## Даатгалын хураамжийн нийт орлого / хэлбэрээр/

| № | Үзүүлэлт | Даатгалын нийт хураамжийн орлого | | Өсөлт/бууралт |
|---|---|---|---|---|
| | | 2016.III | 2017.III | |
| 1 | Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал | 9,270,250,368.1 | 12,852,234,571.8 | 38.6% |
| 2 | Хөрөнгийн даатгал | 26,886,180,276.3 | 30,595,295,165.2 | 13.8% |
| 3 | Автотээврийн хэрэгслийн даатгал | 11,352,789,381.9 | 13,751,019,667.2 | 21.1% |
| 4 | Ачааны даатгал | 1,405,738,391.2 | 1,044,934,788.2 | -25.7% |
| 5 | Барилга угсралтын даатгал | 1,845,174,589.6 | 6,403,280,141.2 | 247.0% |
| 6 | Газар тариалангийн даатгал | 13,699,146.0 | 91,265,567.3 | 566.2% |
| 7 | Мал амьтдын даатгал | 669,887,663.3 | 3,124,408,738.4 | 366.4% |
| 8 | Агаарын хөлгийн даатгал | 2,525,105,580.5 | 1,361,576,340.0 | -46.1% |
| 9 | Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 313,084,263.7 | 372,675,220.7 | 19.0% |
| 10 | Хариуцлагын даатгал | 5,018,596,515.5 | 7,877,789,937.2 | 57.0% |
| 11 | Санхүүгийн даатгал | 2,682,534,614.5 | 2,094,438,108.1 | -21.9% |
| 12 | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 22,354,498,179.1 | 24,576,615,745.7 | 9.9% |
| 13 | Зээлийн даатгал | 637,125,413.6 | 1,994,253,294.4 | 213.0% |
| 14 | Итгэлцлийн даатгал | 279,282,541.6 | 257,873,463.4 | -7.7% |
| 15 | Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | 2,604,442,995.2 | 7,178,780,775.6 | 175.6% |
| 16 | Хугацаат амьдралын даатгал | 115,149,295.6 | 165,602,030.1 | 43.8% |
| 17 | Хуримтлалын даатгал | 60,561,681.0 | 69,451,816.0 | 14.7% |
| 18 | Тэтгэврийн даатгал | 40,212,809.0 | 67,778,022.0 | 68.5% |
| 19 | Эрүүл мэндийн даатгал | 712,934,620.4 | 692,800,386.9 | -2.8% |
| | **Дүн** | **88,787,248,325.9** | **114,502,621,963.4** | **29.0%** |

Дүрслэл-5

## Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт



## 1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Даатгалын тохиолдлын улмаас 2017 оны 3 дугаар улиралд нийт 43,526 даатгуулагчдад 32.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Тайлант хугацаанд “Монгол даатгал” ХХК 6.6 тэрбум төгрөгийн, “Миг даатгал” ХХК 5.3 тэрбум төгрөгийн, “Тэнгэр даатгал” ХХК 4.1 тэрбум төгрөгийн, “Мандал даатгал” ХХК 3.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь хамгийн өндөр бөгөөд нийт нөхөн төлбөрийн 60.8 хувийг эзэлж байна. Нийт салбарын хэмжээнд авч үзвэл нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-7

| № | Компани | Нийт нөхөн төлбөрийн зардал | | Өсөлт/бууралт |
|---|---|---|---|---|
| | | 2016.III | 2017.III | |
| 1 | Ард даатгал | 1,709,206,378.2 | 1,647,599,567.5 | -4% |
| 2 | Бодь даатгал | 2,118,262,203.3 | 2,797,544,325.9 | 32% |
| 3 | Ган зам даатгал | 37,237,440.0 | 58,311,371.0 | 57% |
| 4 | Гэр даатгал | 68,409,078.0 | 268,074,629.0 | 292% |
| 5 | Мандал женерал даатгал | 2,914,354,326.0 | 3,631,930,578.8 | 25% |
| 6 | Миг даатгал | 3,651,928,285.3 | 5,293,931,143.9 | 45% |
| 7 | Монгол даатгал | 4,346,678,427.7 | 6,651,302,379.7 | 53% |
| 8 | Монре даатгал | 1,204,838,664.5 | 1,433,292,124.3 | 19% |
| 9 | Мөнх даатгал | 83,632,949.0 | 49,902,460.0 | -40% |
| 10 | Номин даатгал | 928,897,680.0 | 1,059,694,226.4 | 14% |
| 11 | Практикал даатгал | 2,203,180,326.2 | 2,323,215,240.9 | 5% |
| 12 | Соёмбо даатгал | 1,764,447,873.5 | 1,337,572,110.9 | -24% |
| 13 | Тэнгэр даатгал | 1,610,587,800.1 | 4,136,964,252.4 | 157% |
| 14 | Улаанбаатар хотын даатгал | 133,962,884.0 | 90,115,594.0 | -33% |
| 15 | Хаан даатгал | 776,139,122.0 | 812,452,374.0 | 5% |
| 16 | Нэйшнл Лайф Даатгал | 617,769,876.6 | 818,607,687.5 | 33% |
| 17 | Хөдөө аж ахуйн давхар даатгал | .0 | .0 | |
| | **Дүн** | **24,169,533,314.4** | **32,410,510,066.4** | **34%** |

Даатгалын компаниудын даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар 22,411 даатгуулагчид нийт 11.2 тэрбум төгрөгийн, авто тээврийн хэрэгслийн даатгалаар 9,550 даатгуулагчид 6.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр олгосон даатгалын хэлбэрүүд байна.

Хүснэгт-8

| № | Даатгалын хэлбэр | 2016.09.30 | | 2017.09.30 | |
|---|---|---|---|---|---|
| | | Нөхөн төлбөр | Нөхөн төлбөр авсан гэрээний тоо | Нөхөн төлбөр | Нөхөн төлбөр авсан гэрээний тоо |
| 1 | Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал | 2,411,038,581.9 | 6,921 | 3,380,731,159.1 | 8,144.00 |
| 2 | Хөрөнгийн даатгал | 1,883,420,420.2 | 2,572 | 5,884,547,921.6 | 2,044.00 |
| 3 | Автотээврийн хэрэгслийн даатгал | 5,550,496,311.4 | 10,331 | 6,046,138,609.2 | 9,550.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Ачааны даатгал | 175,396,008.8 | 31 | 1,957,388,405.6 | 48.00 |
| 5 | Барилга угсралтын даатгал | 19,542,580.0 | 1 | 449,544,855.9 | 1.00 |
| 6 | Мал амьтдын даатгал | 174,197,167.2 | 393 | 107,582,218.6 | 65.00 |
| 7 | Агаарын хөлгийн даатгал | 110,982,500.0 | 1 | | |
| 8 | Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 13,139,118.0 | 256 | 30,721,165.4 | 84.00 |
| 9 | Хариуцлагын даатгал | 466,405,557.8 | 514 | 607,046,810.8 | 679.00 |
| 10 | Санхүүгийн даатгал | 1,564,700,457.2 | 483 | 1,413,727,948.7 | 399.00 |
| 11 | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 10,652,333,950.5 | 24,518 | 11,199,700,952.7 | 22,411.00 |
| 12 | Зээлийн даатгал | 499,340,033.5 | 51 | 430,805,068.7 | 94.00 |
| 13 | Итгэлцлийн даатгал | 21,250,000.0 | 1 | | |
| 14 | Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | 9,520,751.1 | 6 | 83,967,262.4 | 6.00 |
| 15 | Хугацаат амьдралын даатгал | 65,299,630.2 | 48 | 51,917,660.4 | 38.00 |
| 16 | Хуримтлалын даатгал | 72,915,242.0 | 47 | 40,510,968.0 | 11.00 |
| 17 | Тэтгэврийн даатгал | 11,459,119.9 | 12 | 16,967,798.0 | 0.00 |
| 18 | Эрүүл мэндийн даатгал | 468,095,884.4 | 1,561 | 709,211,261.0 | 1,417.00 |
| | **Дүн** | **24,169,533,314.4** | **47,747** | **32,410,510,066.4** | **44,991** |

: Тайлант хугацаанд нөхөн төлбөр гараагүй даатгалын хэлбэрүүдийг дээрх хүснэгтэд оруулаагүй болно.

## 1.6.ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 2017 оны 3 дугаар улиралд 62.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 27.0 хувиар өссөн байна. Сүүлийн 5 жилийн хугацааны даатгалын нөөц сангийн өсөлтийг дараах дүрслэлээр харуулав.

Дүрслэл-6

**Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ болон өсөлтийн хувь**




## 1.7.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт хохирлын харьцаа 32.3 хувьтай байна. Үүнд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлогоос тооцсон орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 37.5 хувьтай байна.

Дүрслэл-7




## 1.8.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын компаниудын цэвэр ашиг 2017 оны 3 дугаар улиралд 10.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Дүрслэл-10




## 2.АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

2017 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид "жолоочийн хариуцлагын даатгал" гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж 24.6 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт-9

| **Даатгалын компани** | **Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого** | | |
|---|---|---|---|
| | **2016.09.30** | **2017.09.30** | **Өөрчлөлт** |
| Ард даатгал | 1,342,258,890.76 | 1,503,746,391.28 | 12.0% |
| Бодь даатгал | 2,674,108,206.75 | 3,026,783,523.42 | 13.2% |
| Ган зам даатгал | 20,664,583.00 | 20,525,717.00 | -0.7% |

| | | | |
|---|---|---|---|
| Гэр даатгал | 183,104,733.00 | 620,184,887.00 | 238.7% |
| Мандал женерал даатгал | 2,438,316,869.00 | 1,218,122,967.00 | -50.0% |
| Миг даатгал | 3,130,767,052.66 | 3,822,689,438.52 | 22.1% |
| Монгол даатгал | 4,453,368,449.37 | 4,573,078,702.63 | 2.7% |
| Монре даатгал | 1,434,756,046.23 | 1,896,440,493.86 | 32.2% |
| Мөнх даатгал | 304,131,089.00 | 371,394,703.00 | 22.1% |
| Номин даатгал | 1,478,324,308.22 | 1,646,075,424.65 | 11.3% |
| Практикал даатгал | 1,894,887,752.01 | 2,009,257,007.34 | 6.0% |
| Соёмбо даатгал | 860,879,881.09 | 1,205,912,270.00 | 40.1% |
| Тэнгэр даатгал | 1,319,257,547.00 | 1,678,026,941.00 | 27.2% |
| Улаанбаатар хотын даатгал | 5,776,079.00 | 1,277,383.00 | -77.9% |
| Хаан даатгал | 813,896,692.00 | 983,099,896.00 | 20.8% |
| **Нийт** | **22,354,498,179.09** | **24,576,615,745.70** | **9.9%** |

Тайлант хугацаанд даатгалын компаниуд жолоочийн хариуцлагын даатгалын 22,411 тохиолдолд нийт 11.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Сүүлийн 3 жилийн статистикаас харахад жолоочийн хариуцлагын даатгалын 1 гэрээ тутамд ногдож буй даатгалын тохиолдол болох магадлал нь дараах байдалтай байна.

Дүрслэл-11

**ЖХАЖД-ын тохиолдол**




## 3.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

### 3.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

2017 оны 3 дугаар улиралд даатгалын зуучлалын 40 компаниас 19 компани тайлангаа Фина санхүүгийн системд ирүүлсэн бөгөөд үүнээс 2 компани даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлээгүй байна. Тайлант хугацаанд 10 даатгалын зуучлагч компани, 9 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж ердийн даатгалын 14, урт хугацааны даатгалын 2 хэлбэр зуучилж, 5.2 тэрбум төгрөгийн даатгалын зуучлалын шимтгэлийн орлого төвлөрүүлсэн нь салбарын нийт хураамжийн орлогын 19.8 хувийг бүрдүүлж байна.

/төгрөгөөр/ Хүснэгт-10

| ДД | Даатгалын зуучлагч | 2016.09.30 | | 2017.09.30 | |
|---|---|---|---|---|---|
| | | **Зуучилсан даатгалын хураамжийн орлого** | **Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого** | **Зуучилсан даатгалын хураамжийн орлого** | **Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого** |
| 1 | АМЕ | 1,225,753,477.0 | 66,650,633.0 | 1,961,623,040.0 | 129,844,402.0 |
| 2 | Ай Ай Би | 3,616,374.0 | 988,068.0 | 5,938,833.0 | 1,169,762.0 |
| 2 | Ар Эм Ай Би | - | - | 256,614.0 | 45,768.7 |
| 3 | Ариг банк | 63,425,928.5 | 12,968,298.3 | 71,255,070.9 | 14,670,810.0 |
| 3 | Арм интернэшнл | 11,513,790.2 | 2,832,000.0 | - | - |
| 4 | Асимон брокерс | 2,836,038,600.3 | 203,113,328.6 | 3,669,391,279.2 | 160,401,374.2 |
| 4 | Ачит ундарга | 201,181,841.9 | 27,901,648.0 | 107,732,016.4 | 32,980,862.4 |
| 5 | Бест солюшн | 81,378,047.4 | 8,466,790.9 | 989,786,239.2 | 189,403,828.2 |
| 5 | Ваяснью Солюшн | 544,580,744.0 | 94,798,178.0 | 833,615,745.0 | 161,449,404.0 |
| 6 | Голомт банк | 1,139,144,707.6 | 157,836,430.5 | 2,368,737,986.5 | 347,115,286.6 |
| 6 | Дэвжих дэлгэрэх холдинг | 33,997,306.0 | 6,295,062.0 | 120,252,696.0 | 21,561,150.7 |
| 7 | Капитал банк | 100,466,698.9 | 8,767,763.4 | 104,661,267.5 | 21,519,356.6 |
| 7 | Ковер хилл | 6,964,701.0 | 1,741,175.3 | 88,177,486.0 | 10,897,085.0 |
| 8 | Лояалти солюшн | - | - | 134,988,380.3 | 25,377,575.1 |
| 8 | Мастер шийдэл | - | - | 126,456,615.0 | 36,359,121.6 |
| 9 | Монгол бичээч зууч | 328,749,274.0 | 67,059,220.9 | 211,027,574.0 | 42,481,134.8 |
| 9 | Монголиан иншуранс Брокерейж | 10,094,587.0 | 2,436,700.4 | 24,134,142.0 | 6,106,326.4 |
| 10 | Нэйшнл эженси | 812,791,009.0 | 86,198,410.0 | 536,543,260.0 | 84,496,656.0 |
| 10 | Ренессанс групп | 12,908,672.1 | 2,783,460.5 | 9,559,095.8 | 4,110,324.8 |
| 11 | Си эн эн икс | 445,414,304.1 | 60,617,686.0 | 1,061,691,760.5 | 264,661,091.2 |
| 11 | Смарт брокерс | 752,608,856.0 | 206,795,410.2 | 1,318,803,517.0 | 369,312,980.3 |
| 12 | Сүрэг хараацай | 2,124,732,447.0 | 474,801,640.0 | 2,142,488,597.0 | 452,884,395.2 |
| 12 | Тод капитал | 526,321,093.0 | 87,309,559.2 | 633,464,704.0 | 116,593,494.6 |
| 13 | Төрийн банк | 2,231,493,287.8 | 465,237,240.0 | 2,776,460,660.1 | 546,186,878.0 |
| 13 | Үндэсний хөрөнгө оруулалтын банк | 2,001,778,934.3 | 475,903,765.0 | 1,954,514,711.8 | 412,715,062.6 |
| 14 | Хаан банк | 2,310,040,184.8 | 453,624,067.0 | 3,474,036,287.6 | 686,516,905.7 |
| 14 | ХасБанк | 758,835,612.8 | 151,767,122.6 | 1,266,813,473.5 | 214,697,063.0 |
| 15 | Худалдаа хөгжлийн банк | 2,614,564,536.2 | 390,141,080.9 | 3,290,257,983.8 | 523,973,102.9 |
| 15 | Хүннү сиэл | 5,235,525.0 | 1,427,905.0 | 9,071,970.0 | 1,366,141.5 |
| 16 | Цагаан гэрэлт | 49,856,432.0 | 11,369,206.0 | 42,149,825.0 | 9,223,984.0 |
| 16 | Эй Эс Ай Би | - | - | 206,902,315.1 | 36,724,176.7 |
| 17 | Эл Би брокерэж | 456,781,640.4 | 69,903,407.1 | 1,029,233,407.4 | 230,289,951.0 |
| 17 | Эм жи ай би | - | - | 42,654,801.0 | 11,929,381.8 |
| 18 | Эрсдэлийн шийдэл | 513,643,809.0 | 123,277,375.6 | - | - |
| 18 | Эс ай би эс | 6,921,376.0 | 1,316,993.0 | 38,953,240.0 | 7,164,520.9 |
| 19 | Эс Ти Ди | | | 190,651,987.2 | 28,968,860.2 |
| | **Дүн** | **22,210,833,797.2** | **3,724,329,625.0** | **30,842,286,581.7** | **5,203,198,218.5** |

2017 оны 3 дугаар улиралд даатгалын зуучлагч компани 2.8 тэрбум төгрөгийн, даатгалын зуучлагч банк 2.4 тэрбум төгрөгийн даатгалын зуучлалын шимтгэлийн орлого тайлагнасан бөгөөд нийт даатгалын зуучлалын шимтгэлийн орлого 5.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 39.7 хувиар өссөн байна.




## 3.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Даатгалын хохирол үнэлэгч 31 компаниас 2017 оны 3 дугаар улиралд 22 компани үйл ажиллагаа явуулж тайлант хугацаанд нийт 15,242.8 сая төгрөгийн даатгалын хохирлын үнэлгээ бүхий 17,505 удаагийн даатгалын хохирлын үнэлгээ хийж, 566.2 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ.

/төгрөгөөр/ Хүснэгт-11

| № | Компани | 2016.09.30 | | | 2017.09.30 | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Даатгалын хохирлын нийт үнэлгээ | Даатгалын хохирлыг үнэлсэн тоо | Даатгалын хохирол үнэлгээний орлого | Даатгалын хохирлын нийт үнэлгээ | Даатгалын хохирлыг үнэлсэн тоо | Даатгалын хохирол үнэлгээний орлого |
| 1 | Арвижих эстимэйт | #N/A | #N/A | #N/A | 30,820,043.0 | 89.0 | 2,360,000.0 |
| 2 | Арга билэг эстимэйт | 79,431,691.0 | 173.0 | 4,631,000.0 | - | - | - |
| 3 | Ашид билгүүн | #N/A | #N/A | #N/A | 2,668,566,295.0 | 5,689.0 | 172,207,382.0 |
| 4 | Банхас | 230,825,400.0 | 381.0 | 6,921,000.0 | 400,974,108.0 | 741.0 | 11,955,000.0 |
| 5 | Бэст эстимэйт | 188,926,000.0 | 101.0 | 3,773,842.7 | 4,448,712,944.0 | 38.0 | 47,439,090.9 |
| 6 | Вендо | #N/A | #N/A | #N/A | 2,314,537,937.0 | 2,087.0 | 56,867,338.2 |
| 7 | Виннэрвэй | 3,367,225.0 | 8.0 | 206,000.0 | 34,543,000.0 | 18.0 | 826,300.0 |
| 8 | Гэрэгэ эстимэйт | #N/A | #N/A | #N/A | 718,687,736.0 | 1,592.0 | 55,714,533.6 |
| 9 | Итгэлт эстимэйт | 188,618,486.0 | 307.0 | 7,147,270.2 | 304,639,415.0 | 270.0 | 10,436,818.0 |
| 10 | Кости эстимэйт | 496,095,399.0 | 1,264.0 | 23,742,273.0 | 641,540,600.0 | 1,575.0 | 31,450,000.0 |
| 11 | Лэндс | 549,578,992.0 | 1,267.0 | 24,350,909.1 | #N/A | #N/A | #N/A |
| 12 | Мастер Үнэлгээ | 381,996,540.0 | 684.0 | 20,658,536.4 | 701,757,800.0 | 886.0 | 32,057,272.7 |
| 13 | Сэлэнгэ эстимэйт | 99,516,337.0 | 81.0 | 3,940,000.0 | 27,330,900.0 | 59.0 | 1,383,000.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Тэгшсонголт эстимэйт | 13,500,740.0 | 19.0 | 476,000.0 | 5,558,900.0 | 20.0 | 299,090.8 |
| 15 | Тэнцвэр эстимэйт | 26.0 | 26.0 | 682,000.0 | 614,148,764.0 | 560.0 | 18,300,500.0 |
| 16 | Ухаашүрт консалтинг | 599,933,904.0 | 1,899.0 | 18,517,727.0 | 821,255,220.0 | 2,178.0 | 35,188,181.8 |
| 17 | Фэйр валуэшн | 384,704,206.0 | 964.0 | 23,566,950.0 | 345,012,058.0 | 736.0 | 19,673,500.0 |
| 18 | Хас үнэлгээ | 6,965,000.0 | 1.0 | 151,000.0 | 9,155,000.0 | 2.0 | 198,000.0 |
| 19 | Файн эстимэйт | #N/A | #N/A | #N/A | 380,000.0 | 2.0 | 45,000.0 |
| 20 | Үнэлгээ консалтинг | #N/A | #N/A | #N/A | 40,208,050.0 | 117.0 | 2,830,500.0 |
| 21 | Хөрөнгө эстимэйт | 326,561,820.0 | 232.0 | 24,834,950.0 | 395,920,287.0 | 708.0 | 24,646,500.0 |
| 22 | Голд стандарт эстимейт | #N/A | #N/A | #N/A | - | 64.0 | 1,800,000.0 |
| 23 | Мөнх эстимэйт | #N/A | #N/A | #N/A | 676,967,745.1 | 11.0 | 8,450,000.0 |
| 24 | Тод үнэлгээ | #N/A | #N/A | #N/A | 42,066,383.0 | 63.0 | 32,111,683.0 |
| | **Дүн** | **3,550,021,766.0** | **7,407.0** | **163,599,458.4** | **15,242,783,185.1** | **17,505.0** | **566,239,691.1** |

## ДААТГАЛЫН ГАЗАР